



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 7 дугаар сарын
27-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 312

ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ, ИМПОРТЫГ ОРЛОХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛҮҮДИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТУХАЙ

Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн банкны тухай хуулийн 8.1, 9.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үйлдвэржилтийг дэмжих зорилтуудын хүрээнд 2015-2016 онд төсөл хэрэгжүүлэх үйлдвэрлэлийн чиглэлүүдийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хавсралтаар баталсан үйлдвэрлэлийн чиглэлүүдэд хамаарах экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн төслүүдэд 300.0 (гурван зуу) хүртэлх тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкуудаар дамжуулан олгох арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн сайд Д. Эрдэнэбат, Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 212 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Аж үйлдвэрийн сайд

Д.ЭРДЭНЭБАТ

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД 2015-2016 ОНД ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛҮҮД**

А. Хүнд үйлдвэрийн салбар	
1	Төмөрлөгийн үйлдвэрлэл
2	Зэс боловсруулах үйлдвэрлэл
3	Газрын тос болон газрын тосны дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл
4	Нүүрс боловсруулах үйлдвэрлэл
5	Металл боловсруулалт, машин үйлдвэрлэл
6	Химийн үйлдвэрлэл
7	Цемент, шохойн үйлдвэрлэл
8	Шил, шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
Б.Хөнгөн үйлдвэрлэлийн салбар	
1	Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл
2	Сав, баглаа боодлын үйлдвэрлэл
3	Ой модны үйлдвэрлэл
4	Барилгын материалын үйлдвэрлэл
5	Дахин боловсруулах үйлдвэрлэл